

ЯДУУРАЛ БА ЭМЗЭГ БАЙДАЛ

Г. Цагаач, докторант, Эдийн засгийн тэнхимийн багш,
Нийгмийн Ухааны салбар, Шинжлэх Ухааны Сургууль, Монгол Улсын Их Сургууль

Хураангуй

Ядуурлын чиглэлээрх судалгаа Монгол улсад цөөнгүй хийгдэж ирсэн ч ядуурах эмзэг байдлын асуудал тун хангалтгүй хэмжээнд хөндөгдөж ирлээ. Ядуурлыг бууруулах бодлого төдийлөн үр дүнтэй байж чадахгүй байгаагийн нэг гол шалтгаан нь хүн амаа ядуурахаас сэргийлэх тал дээр дорвитой ажил хийхгүй байгаатай холбоотой хэмээн үзэж болно. Энэ өгүүлэлд эрсдэл, эмзэг байдлын асуудал ядуурлын судалгаанд яагаад чухал болохыг голлон тайлбарлав. Үүний тулд ядуурлын онол арга зүй, судалгааны чиг хандлагад гарсан өөрчлөлтийг түүхэн хугацааных нь дарааллаар өгүүлж, ядуурах эмзэг байдлыг үнэлэн тооцож буй үндсэн аргуудаас цухас дурьдав. Ядуурал динамик шинжтэй болох нь олон судалгаагаар нотлогдож буй тул ядуу хүн амын бүлгийг “нэг төрлийн бүлэг” гэж үзэх боломжгүй байна.

Түлхүүр үгс: Ядуурал, эрсдэл, эмзэг байдал, ядуурах эмзэг байдал

Abstract

Although there were many poverty related studies carried out in Mongolia, the issue of vulnerability to poverty has been touched upon very poorly. It can be considered that one of the main reasons that the policy for poverty reduction is not really effective is due to insufficient activities to prevent from poverty. In this article, it is explained mainly why risk and vulnerability issues are important for poverty studies. For this, the historic chronological changes in the poverty theory, methodology and research trend is described and the key methods used to evaluate vulnerability to poverty are briefly stated. Many studies prove that poverty is of dynamic nature and therefore poor group of people cannot be considered a “homogenous group”.

Key words: Poverty, Risk, Vulnerability, Vulnerability to Poverty

ОРШИЛ

Ядуурал хөгжиж буй нийт орнуудын хувьд анхаарал татсан, макро эдийн засгийн тулгамдсан асуудлын нэгд тооцогдсоор байна. Засгийн газар бүр энэ асуудалд тодорхой хэмжээгээр анхаарал хандуулан ажиллаж ирсэн ч дийлэнх нь аль хэдийн ядууралд өртөөд “ядуу” хэмээх ангилалд багтах болсон иргэдээ ядуурлаас гаргах, тоог нь цөөрүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэхэд түлхүү анхаарч ирсэн юм. Нөгөөтэйгүүр, өнөөдөр “ядуу биш” боловч ирээдүйд ядуурч мэдэх хүн ам, мөн өнөөдөр ядуу хэмээн тооцогдож буй хүн амын цаашид улам ядуурч болзошгүй байдал - ядуурах эмзэг байдлыг судлан тогтоож, ядуурлаас сэргийлэх бодлого боловсруулан, хэрэгжүүлэхэд багагүй анхаарах болсон ба энэ чиглэлийн судалгааны ажлын тоо сүүлийн арав гаруй жилд мэдэгдэхүйц өсч, арга зүй нь улам боловсронгуй болж байна. Энэ өгүүлэлд эрсдэл, эмзэг байдал, ядуурлын уялдааг голлон тайлбарлав. Эхний хэсэгт ядуурлын

онол арга зүй, судалгааны чиг хандлагад гарсан өөрчлөлтийн тухай, дараагийн хэсэгт эрсдэл, шок тэдгээрийн ядууралд үзүүлэх нөлөө, удаах хэсэгт эмзэг байдал ба ядуурлын тухай өгүүлэв.

ЯДУУРЛЫН ОНОЛ АРГА ЗҮЙ, СУДАЛГААН ДАХЬ ӨӨРЧЛӨЛТ

Ядуурлын асуудал бүх нийгэмд, түүхийн бүхий л үед судлаачид болон бодлого боловсруулагчдын анхаарлын төвд байж ирсэн. Ядуурлыг шинжлэх ухааны үндэстэй судлах ажил тэртээ 1900-аад оны эхэн үетэй холбогддог. 1900-аад оны эхэнд Английн Иорк хотын ядуу, ажилчин ангийн иргэд амьдралын наад захын хэрэгцээгээ хангаж чадаж буй эсэхийг хүнс тэжээлийн болон бусад хэрэгцээ шаардлагад нь тулгуурлан судалж, ядуурлын стандарт үзүүлэлтийг тогтоохыг оролдсон нийгэм судлаач Rowntree (1901)-ийн багийнхны судалгаа ядуурлын чиглэлээрх шинжлэх ухааны үндэслэлтэй судалгааны ажлуудын

анхдагчид тооцогддог. Энэ ажил орчин цагт ч агуулга, арга зүйн хувьд хоцрогдоогүй бөгөөд тайлан нь 2000 онд шинэчлэгдэн хэвлэгдсэн нь нийгэм судлаачдын хувьд үнэ цэнэтэй ажилд тооцогдож байна.

Rowntree судалгаагаа үргэлжлүүлэн үр дүнг нь 1935, 1951 онд тус тус хэвлүүлсэн байдаг. Хоёр дахь ажилдаа ядуурлын шугамыг өмнөхөөсөө арай өөрөөр тодорхойлсон, мөн гурав дахь ажилдаа түүвэр судалгааны аргыг хэрэглэснийг эс тооцвол үндсэн арга зүйн хувьд анхныхаасаа бараг өөрчлөлтгүй ажлууд болсон байна.

Англид 1900-аад оны эхэн үед өрхийн ядуурлын гол шалтгаан нь цалингийн доогуур түвшин, харин 1930-аад оны үед ажилгүйдэл болж байв. Харин 1950-аад оны эхэн үед тухайн үеийн нийгмийн бодлоготой холбоотойгоор /халамжийн болон бүрэн ажил эрхлэлтийн бодлого/ абсолют ядуурал тийм ч хурц асуудалд тооцогддоггүй байсныг Rowntree-ийн судалгаанууд харуулдаг юм (en.wikipedia.org).

1960-аад онд ядуурлын чиглэлээрх судалгааны гол судлагдахуун нь орлогын түвшин буюу нэг хүнд ногдох Үндэсний нийт бүтээгдэхүүн зэрэг макро эдийн засгийн үзүүлэлтэд тусгалаа олсон үзүүлэлт байлаа. Нийгэм, эдийн засгийн хөгжлийг даган 1970-аад оны үеэс ядуурлын асуудал бүх нийтийн анхаарлыг зүй ёсоор татах болсон ба үүнийг Дэлхийн банкны ерөнхийлөгч асан McNamara-гийн 1973 онд Найробид Дэлхийн банкны Удирдах зөвлөлийн хуралд танилцуулсан илтгэлийн үр дүн гэх нь бий. Тэрээр илтгэлдээ (McNamara, 1973) орлогын тэгш бус байдал хөгжингүй болон хөгжиж буй орнуудын хооронд нэмэгдээд зогсохгүй, хөгжиж буй орнуудын хувьд улам гүнзгийрсэн болохыг, мөн хөгжиж буй орнуудын хоёр тэрбум иргэний 40 орчим хувь нь абсолют ядууралд өртсөн болохыг, цаашилбал хөдөөгийн ядуурал илүү их анхаарал татахуйц болж буйг онцлон тэмдэглэж, хөгжлийн дэмжлэг туслалцааг эдгээр чиглэлд хандуулахыг санал болгон, зөвлөсөн байдаг.

Гэвч, 1970-аад оноос зарим судлаач, тухайлбал Английн судлаач Townsend (1970) ядуурлыг абсолют гэхээс илүү харьцангуй

үзүүлэлт гэж үзэх нь оновчтой гэсэн санааг дэвшүүлэн, “Хүмүүсийн хэрэгцээ, хүнсний хэрэгцээ нь хүртэл тэдний амьдарч, харъяалагдаж буй нийгмээс хамаарах ба янз бүрийн нийгэмд, цаашилбал тухайн нийгмийн хөгжлийн янз бүрийн үед өөр өөр хэрэгцээ оршино” гэсэн байдаг. Мөн дан ганц амьжиргааны доод түвшинг хангаж чадахгүй байгаагаас бус тухайн нийгэмд тогтсон стандартуудыг хангаж чадахгүй байгаагаас хүмүүс ядууралд өртөж байна хэмээн үзэж, харьцангуй доройтол, ядуурлын асуудлыг чухалчилж байсан. Түүний энэ санаа 1970-аад оны дунд үед ОУХБ-ын ажилд тусгалаа олж, ядуурлыг дан ганц орлогын хомсдолын үр дүн биш, эрүүл мэнд, боловсрол, нийгмийн бусад үйлчилгээний хүртээмжгүй байдлаас үүдэлтэй гэх болсон билээ.

1980-аад оноос ядуурлын онол, судалгаанд шинэ үе эхэлсэн гэж үзэж болно. Philip болон Rayhan (2004) нарын тэмдэглэсэнчлэн энэ үеэс:

1) Эрх мэдэлгүй байх, алслагдсан газар амьдардаг байх зэрэг мөнгөөр үл хэмжигдэх хүчин зүйлсийг ядуурлын судалгаанд харгалздаг болсон.

2) Ган, зуд гэх мэт шок, улирлын хүчин зүйлийн нөлөөг таньж мэдэхийн тулд эмзэг байдал, түүнээс салгашгүй ухагдахуун болох аюулгүй байдлыг судлах сонирхол өсөн нэмэгдсэн. Үүнээс улбаалан эрсдлийг даван туулах стратегийн судалгаа улам их хийгдэх болсон.

3) Ядууралхэмээх ойлголтыг “амьжиргаа” гэсэн том хүрээнд харах болсон.

4) Орлого нь хувь хүмүүсийг чадавхижуулж, нийгэмд тодорхой байр суурь эзэлж, үйл хөдлөл хийх боломжийг олгодоггоороо үнэ цэнэтэй болохыг Amartya Sen (1981) нарын эрдэмтэн судлаач бүтээлдээ онцолж эхэлсэн.

5) Жендэр судлал эрчтэй хөгжиж, эмэгтэйчүүдэд эрх мэдэл олгох, бие даасан байдлыг нь нэмэгдүүлэхэд бодлого чиглэх болсон.

Харин 1990-ээд оноос хүний хөгжлийн асуудал ядуурлын судалгаатай нягт уялдаж болсон ба “урт удаан, эрүүл саруул, бүтээлч

амьдралд хөтлөх, мөн амьжиргааны зохистой стандартыг бүрдүүлэн, эрх чөлөөтэй, нэр төртэй, өөртөө итгэх итгэлтэй амьдрах боломж, сонголтыг үгүйсгэх”-ийг хүний хөгжлийг хаан боомилох гэж үзэж байв (Simon, 1999). Ядууст чиглэсэн өсөлтийн бодлогыг хүний хөгжлийн бодлоготой хослуулан хэрэгжүүлэх нь ядуурлыг бууруулахад хангалттай нөхцөл болно гэж тооцож байсан ч гаргасан хүчин чармайлтын үр дүн тааруу болох нь олон тохиолдолд батлагдаж, ядуурлын динамик шинжийн талаарх ойлголт улам гүнзгийрэх болсон.

1980-аад оны сүүл, 1990-ээд оны эхэн үеэс ядуурлын онол, арга зүй, судалгаанд бий болсон өөрчлөлтүүдийг Shaffer (2001) өөрийн ажилд маш тодорхой схемчлэн үзүүлсэн байдаг (Зураг 1). Түүний үзэж байгаагаар гурван гол өөрчлөлт бий болжээ.

Нэгд, ядуурлын тухай ойлголт дөрвөн чиглэлд өргөжин тэлсэн. Үүнд: а) Ядуурал нь загварын хувьд үндсэн материаллаг хэрэгцээ буюу биологийн хэрэгцээгээ хангаж чадахгүй байхад тулгуурладаг *физиологийн загвараас* бие даасан байдалгүй байх, эрх мэдэлгүй байх, өөрийгөө үл хүндлэх гэх мэт хүчин зүйлд суурилдаг *нийгмийн загварт* шилжсэн; б) Эмзэг байдал, ядуурлын хамаарлыг шинээр авч үзэх болсон; в) Тэгш бус байдал, ядуурлын хамаарлыг дахин гол асуудлын нэг гэж үзэх болсон; г) Ядуурлыг хүний үндсэн эрх зөрчигдөх хэмээн үзэх үзэл түгэн дэлгэрсэн.

Хоёрт, өмнө нь судлаачдын анхаарлыг тун бага татаж байсан хүчин зүйлс ядуурлын учир шалтгааныг өргөн хүрээнд харахад хүргэж, нэмэгдэн орж ирсэн. 1990-ээд оноос өмнө ядуурлын стандарт судалгаа дийлэнх тохиолдолд эдийн засгийн болон хүмүүн капитал¹-д тулгуурлаж байсан бол 1990-ээд оноос эдгээрээс гадна нийгмийн, улс төрийн, соёлын, албадлагын, байгалийн капитал асар их үүрэг гүйцэтгэх болсон. Эдгээрт гарсан өөрчлөлт ядууралтай холбоотой нийгмийн өөрчлөлтийг бий болгодог ба дараахь элементүүдийг хамаатуулан ойлгодог. Үүнд:


- Эдийн засгийн капитал: *үйлдвэрлэлийн хүчин зүйлс, эдийн засгийн хөрөнгө, зээл*
- Хүмүүн капитал: *хувь хүний шинж чанар, онцлог*
- Нийгмийн капитал: *нийгмийн харилцаа, сүлжээ, байгуулалт*
- Улс төрийн капитал: *улс төрийн албан болон албан бус сүлжээ*
- Соёлын капитал: *нийгмийн бүлгүүдийн эрх, үүрэг, байр суурийг тодорхойлох норм, хэм хэмжээ, итгэл үнэмшил, үнэт зүйлс*
- Албадлагын капитал: *нийгмийн норм стандартуудыг хэрэгжүүлэх, нийгмийн харилцаа холбоог тогтоох арга хэрэгсэл*
- Байгалийн капитал: *байгалийн нөөц баялгийн чанар, тоо хэмжээ, тэдгээр баялгийн менежментийг хийх, хадгалан хамгаалахад шаардлагатай мэдлэг, ур чадвар*

Гуравт, ядуурлын тоо хэмжээний өөрчлөлтөөс илүү ядууралд орж, гарч буй хүмүүсийн хөдөлгөөнд түлхүү анхаарах болсон.

Ийнхүү, ядуурлын онол, арга зүй, судалгааны чиг хандлага өнгөрсөн хугацаанд их өөрчлөгдөж ирсэн байна. Дийлэнх нь “ядуурал”-д түлхүү анхаарсан, ихээхэн ач холбогдол өгсөн байдалтай боловч ядуусын зарим нь цаг үргэлж ядуу биш (Yaqub, 2000) байдаг нь тодорхой тул ядуурлыг “тогтвортой” (статик) гэхээс илүү “тогтворгүй” (динамик) үзүүлэлт гэж үзэх хандлага улам нэмэгдэж буй ба энэ байдал хүн амын сайн сайхан аж байдлын талаарх онол, арга зүй, судалгааны хувьд ч, бодлого боловсруулалтын тухайд ч тун чухал болж байна.

1 “Капитал” хэмээх нэршлийг өргөн хүрээнд нийгмийн зорилгыг хангахад ашиглах “нөөц”, “хөрөнгө” гэж ойлгож, хэрэглэдэг (Зохиолч).

Зураг 1. Ядуурлын онол, арга зүй дэх шинэ сэтгэлгээ: Гурван өөрчлөлт



Эх сурвалж: Shaffer (2001)

ЭРСДЭЛ, ШОК

Ядуурлын динамик шинж давамгайлахад нөлөөлж буй гол хүчин зүйл нь “эрсдэл”. Онолын хувьд, эрсдэл нь өрхийн шийдвэр гаргалтанд нөлөөлөх бүрэн боломжтой, жишээ нь ирээдүйн орлого бүрдүүлэлт дэх эрсдлийг бууруулахын тулд өрх эрхэлж буй аж ахуйдаа шинэ технологи нэвтрүүлэх үү, дахин хүүхэдтэй болох уу гэх мэт асуудлын оновчтой шийдлийг олох хэрэгтэй болно. Эрсдэл нь муу зүйл авчрах вий гэсэн айдас. Шок нь эрсдлийн бодит байдал, биелэл, мөн чанар (Heitzmann, Canagarajah and Siegel, 2002). Дийлэнх тохиолдолд хүмүүс эрсдэлтэй үзэгдэлд нөлөөлж чаддаггүй ч эрсдэл болон шокиг зүгээр л тайван хүлээн авдаггүй, түүнээс зайлсхийх, сөрөг үр дагаврыг нь бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг эрмэлздэг.

Ядуурлын судалгаа голчлон өрхийн түүвэр судалгаанд суурилдаг ба энэ төрлийн судалгааны дийлэнх нь шокийн нөлөөг бүрэн илрүүлэх хэмжээнд загварчлагдаагүй байдаг. Тиймээс, өрхийн түүвэр судалгаанд зөвхөн тухайн өрхөд тулгарсан шок болон нийт өрхийг хамарсан шокийн талаарх мэдээлэл огт байхгүй байх, байлаа ч тун хязгаарлагдмал хэмжээтэй байх нь олонтаа (Azam and Imai, 2009). Зөвхөн нэг л өрхөд тулгарах шок нь олон янзын, урьдчилан таамаглахад бэрх хүчин зүйлсийн нөлөөг агуулах хандлагатай байдаг бөгөөд тухайн өрхийн гишүүдээс эдийн засгийн хувьд идэвхитэй, насанд хүрсэн хэн нэг нь урт хугацаагаар өвдөх нь өрхийн баялаг хуримтлалд сөргөөр нөлөөлдөг энэ төрлийн шокийн жишээ. Харин ган, зуд, үер, их хэмжээний газар нутгийг хамарсан гал түймэр зэрэг нь биет хөрөнгийг сүйтгэх үр дагавартай ковариат буюу нийт

өрхийг хамардаг шокын жишээ юм.

Ligon, Schechter (2003) нарын үзэж байгаагаар ядуурал, эрсдэл хоёр нь сайн сайхан аж байдлын түвшинг буурахад бараг ижил үүрэг гүйцэтгэдэг бөгөөд ковариат шок нь таамаглагдах боломж талаасаа илүү ач холбогдолтой, өрхийн тэргүүн нь боловсролтой, ажил эрхэлдэг өрх бусад өрхтэй харьцуулахад энэ төрлийн шоконд тийм ч эмзэг биш байдаг байна.

Эрсдлийг удирдан зохицуулахын тулд эрсдэл үүсэхээс өмнө түүнээс хамгаалах буюу эрсдлийн нөлөөг бууруулах (ex-ante) стратеги болон эрсдэлтэй үзэгдлийн үр дагаврыг багасгахыг, өөрөөр хэлбэл эрсдэлтэй үзэгдлийг даван туулахыг оролдох (ex-post) стратегис сонгон хэрэгжүүлдэг. Гэхдээ ямар ч арга хэмжээг сонгон хэрэгжүүлсэн, шок өрхийн хэрэглээнд сөргөөр нөлөөлсөн хэвээр үлддэг.

ЭМЗЭГ БАЙДАЛ, ЯДУУРАХ ЭМЗЭГ БАЙДАЛ

Эрсдэл, ядуурлын уялдаа холбоог сайтар таньж мэдэх нь ядуурлыг бууруулахад микро түвшинд тулгардаг зарим гол хүндрэлтэй асуудлыг, тухайлбал хэн хамгийн их эмзэг байдалд байна вэ, ядуурах, ядуурлаас гарахад нөлөөлж буй үндсэн хүчин зүйлс (өрхийн тодорхой шинж тэмдэг гэх мэт) юу вэ гэдгийг тодорхойлж, илрүүлэхэд ихээхэн ач холбогдолтой бөгөөд энэ нь бодлого боловсруулагчдад байдлыг тун тодорхой болгож өгдгөөрөө ач холбогдолтой (Ajaya and Rana, 2005).

Ядуус байгалийн, улс төрийн гээд янз бүрийн эрсдэлд хамгийн их өртөмтгий, мөн тэдэнд эрсдлийг даван туулах арга хэрэгсэл тун бага байдаг. Нийгмийн бусад бүлэгтэй харьцуулахад аливаа шок ядуусын амьжиргаанд хамгийн их сөрөг нөлөөг үзүүлдэг тул хамгийн эмзэг бүлэгт тооцогддог. Улмаар ядуус эрсдлээс боломжоороо зайлсхийгчид болж хувирдаг ба өндөр үр ашигтай ч нөгөөтэйгүүр эрсдэл ихтэй үйл хөдлөл хийх хүсэлгүй болдог (World Bank, 2003).

Эмзэг байдлыг ядуурлын шалтгаан, ядуурлын үндсэн шинж тэмдэг, мөн

ядуурлын бүрэлдэхүүн хэсэг гэж үзэж болно. Өөрөөр хэлбэл, эмзэг байдал нь ядууралтай нягт холбоотой ч ихээхэн ялгаатай сайн сайхан аж байдлын үзүүлэлт. Ядуурал тогтвортой үзүүлэлтэд тооцогдож ирсэн бол эмзэг байдал (тодорхой хэлбэл, ядуурах эмзэг байдал) нь тогтворгүй - тодорхой цаг хугацаан дахь өөрчлөлтийг агуулсан үзүүлэлтэд тооцогддог (Moser, 1998).

Эмзэг байдал бодит асуудал болох нь нэгэнт тодорхойлогдсон зүйл. Аливаа аюул, гамшгийн хувь хүн, олон нийт, нийгэм-эдийн засгийн бүтэц, тогтолцоонд үзүүлэх нөлөөг тодорхойлоход эмзэг байдал нь нийгмийн болон бусад шинжлэх ухаанд задлан шинжилгээний хэрэгсэл болж өргөн ашиглагддаг. Эмзэг байдлыг дийлэнх тохиолдолд ядуурал ба хөгжил, аюулгүй байдал, нийтийн эрүүл мэнд, цаг агаарын өөрчлөлттэй уялдуулан судалж байна. Эмзэг байдлыг бусад олон талын ойлголттой нэгдмэл ойлголт гэж үзэж болох ч судлаачид нэгдсэн ойлголтод хараахан хүрээгүй байгаа тул холбогдох судалгаа шинжилгээний ажлыг нээлттэй гэж үзэж болно.

Эмзэг байдлын олон тодорхойлолт байна. Орлогод сөргөөр нөлөөлөх шок тохиоход хэрэглээнийхээ түвшинг хэвээр нь хадгалж чадах чадвар муутай өрхийг “эмзэг” гэж үзэх хандлага (Chaudhuri and others, 2002) байгаа ба энэ тохиолдолд тухайн өрхийн хэрэглээ нь орлогод сөргөөр нөлөөлөх шокоос хэт мэдрэг гэсэн үг. Энэ тодорхойлолтод хоёр асуудал байна. Эхнийх нь, эмзэг байдлыг дан ганц өрхийн хэрэглээнийхээ түвшинг хэвээр хадгалж чадах чадвараар тодорхойлох нь учир дутагдалтай. Учир нь орлогын шоконд өртөмтгий байдал өрхүүдийн хувьд өөр өөр байдаг. Өрх хэрэглээгээ хэвээр нь хадгалах чадвар султай боловч харьцангуй цөөн төрлийн шоконд өртөмтгий байж мэднэ. Удаах асуудал нь өрхийн хэрэглээнийхээ түвшинг хэвээр хадгалах чадамжид түлхүү ач холбогдол өгснөөр эмзэг байдлын тухай ойлголтын асимметрик шинжийг алдагдахад хүргэж байна.

Үүнээс гадна, ядууралд өртөх гэхээс илүү сайн сайхан аж байдлын түвшинг доройтуулах шоконд өртөхүйц байдлыг эмзэг байдал гэж үзэх хандлага байдаг.

Энэ тодорхойлолтод ч бас зохих хэмжээний асуудал байна. Учир нь өнөөдөр ядуу, цаашид шок болохгүй байсан ч ядуу хэвээр үлдэх магадлал өндөртэй өрхүүдийн асуудал тодорхойгүй үлдэж байна.

Chaudhuri (2002) нарын судлаач эдгээр сул талыг нөхсөн байдлаар ядуурах эмзэг байдлыг өрхийн ойрын ирээдүйд ядуурах магадлал (ядуу биш нь ядуурах, мөн ядуу нь улам ядуурах) хэмээн үзэж, үнэлэх аргыг санал болгосон байдаг. Үүнээс гадна ханамжийн хүлээгдэж буй доод утга (low expected utility) хэмээн ядуурах эмзэг байдлыг үнэлэх арга байна (Ligon and Schechter, 2003). Эдгээр аргууд өөр өөрийн гэсэн давуу, мөн сул талтай ч аль аль нь өрхийн шинж чанарт тулгуурласан, шокоос хамааран өөрчлөгдөж мэдэх хэрэглээний зардлын зохимжит магадлалт тархалтыг байгуулахад тулгуурладаг. Улмаар байгуулсан магадлалт тархалтын функцыг ашиглан ядуурлын FGT индексстэй (Foster et al., 1984) төстэй эмзэг байдлын үзүүлэлтийг үнэлнэ.

Ядуурах эмзэг байдлын үнэлгээ нь урт хугацааг хамарсан панэл тоо мэдээг шаарддаг ч олонх хөгжиж буй оронд найдвартай панэл тоо мэдээ ховор тохиодог. Гэсэн хэдий ч, ядуурах эмзэг байдлын судалгаа сүүлийн арав гаруй жилд багагүй хийгдэж, судлаачдын анхаарлыг зүй ёсоор татах болсон.

Иймээс, ядуурлыг бууруулах асуудлыг гол зорилгоо болгож буй нөхцөлд төрийн бодлого ядуу болох нь аль хэдийн тодорхой бүлэгт чиглэж, ядуурлыг бууруулахад чиглээд зогсохгүй, ядуурч мэдэх, мөн ядуурлынх нь түвшин улам гүнзгийрч мэдэх бүлгийг дэмжин тусалж, ядуурлаас сэргийлэх, өөрөөр хэлбэл янз бүрийн шокын нөлөөгөөр ядууралд өртөж мэдэх эмзэг хэсгийг хамгаалахад чиглэх нь зүйтэй. Ядуурлаас сэргийлэх асуудлыг эрсдлийн менежментийн урьдчилан сэргийлэх, бууруулах, даван туулах гэсэн гурван стратегийг онцлон тодорхойлсон Нийгмийн эрсдлийн менежментийн хүрээ баримт бичигтээ World Bank (2003) онцлон дурьдсан байдаг. Мэдээж, эрсдлийн менежментийн үр дүнтэй стратегийг боловсруулан, хэрэгжүүлэхийн тулд эрсдэл, эмзэг байдлын үнэлгээг хийх нь зүйтэй.

ДҮГНЭЛТ

Ядуурлын онол, арга зүй, судалгааны чиг хандлага өнгөрсөн хугацаанд ихээхэн өөрчлөгдөж ирсэн байна. Дийлэнх нь “ядуурал”-д түлхүү анхаарсан, их ач холбогдол өгсөн байдалтай боловч ядуусын зарим нь цаг үргэлж ядуу биш байдаг нь тодорхой тул ядуурлыг “тогтвортой” (статик) гэхээс илүү “тогтворгүй” (динамик) үзүүлэлт гэж үзэх хандлага улам нэмэгдэж байна. Үүнээс, ядуу хүн амын бүлгийг “нэг төрлийн бүлэг”-т тооцож болохгүй гэдэг нь харагдаж байна.

Ядуурлын динамик шинж давамгайлахад нөлөөлж буй гол хүчин зүйл нь “эрсдэл”. Эрсдэл, ядуурлын уялдаа холбоог сайтар таньж мэдэх нь ядуурлыг бууруулахад микро түвшинд тулгардаг гол хүндрэлтэй асуудлыг тодорхойлж, илрүүлэхэд ихээхэн ач холбогдолтой бөгөөд энэ нь бодлого боловсруулагчдад байдлыг тун тодорхой болгож өгнө.

Эцэст нь тэмдэглэхэд, хөгжиж буй орнуудын Засгийн газруудын ядуурлын эсрэг бодлого, стратеги ядуурлыг бууруулахын зэрэгцээ ядуурлаас урьдчилан сэргийлэхэд чиглэх нь үр дүнтэй гэдэг нь тодорхой байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ:

Ajay, T. and Rana, H. (2005). *Conceptualizing and Measuring Poverty as Vulnerability: Does It Make a Difference?* © Asian Development Bank. <http://hdl.handle.net/11540/1471>. License: CC BY 3.0 IGO. –Available at: <https://openaccess.adb.org/handle/11540/1471#sthash.iIQFrvJj.dpuf>

Azam, S. and Imai, K. (2009). *Vulnerability and Poverty in Bangladesh*, ASARC Working Paper 2009/02.

Chaudhuri, S., Jalan, J. and A. Suryahadi (2002). *Assessing Household Vulnerability to Poverty from Cross-sectional Data: A Methodology and Estimates from Indonesia*. Discussion Paper #: 0102-52. Department of Economics, Columbia University, New York.

- Foster, J. E., J. Greer, and E. Thorbecke (1984). *A Class of Decomposable Poverty Indices*. *Econometrica*, 52: 761-766.
- Heitzmann, K., R. S. Canagarajah, and P. B. Siegel (2002). *Guidelines for Assessing the Sources of Risk and Vulnerability*. Social Protection Discussion Paper 0218. Washington, D.C.: World Bank.
- Ligon, E., and Schechter, L. (2003). *Measuring Vulnerability*. *The Economic Journal*, 113 (March), C95-C102 Royal Economic Society 2003. Blackwell Publishing.
- McNamara, R.S. (1973). *The Nairobi speech: Address to the Board of Governors*
Available at: http://www.juerg-buergi.ch/resources/Archiv/Entwicklungspolitik-Archiv/Dokumente-zur-Entwicklungspolitik/McNamara_Nairobi_speech.pdf
- Morduch, J. (2004). *The American Economic Review*, Vol.84, No.2, Papers and Proceedings of the Hundred and Sixth Annual Meeting of the American Economic Association (May, 1994), 221-225.
- Moser, C. (1998). *The Asset Vulnerability Framework: Reassessing Urban Poverty Reduction Strategies*, *World Development* Vol.26, No.1, pp 1-19.
- Philip, D. and Rayhan Md. I. (2004). *Vulnerability and Poverty: What Are the Causes and How Are They Related*. ZEF. Bonn.
- Sen, A. (1981). *Poverty and Famines: An Essay on Entitlement and Deprivation*. London. Oxford University Press.
- Simon, M. (1999). *The Meaning and Measurement of Poverty*. By Simon Maxwell (1999)
Available at: <http://www.odi.org.uk/publications/briefing/poverty/index.html>
- Shaffer, P. (2001). *New Thinking on Poverty: Implications for Poverty Reduction Strategies*. Paper Prepared for the United Nations Department for Economic and Social Affairs (UNDESA) Expert Group Meeting on Globalization and Rural Poverty United Nations, November 8-9, 2001.
- Townsend, P. (1970). *The Concept of Poverty*. London: Heinemann.
- World Bank (2003). *Social Risk Management: The World Bank's Approach in a Globalizing World*, Washington, D.C.
- Yaqub, S. (2000). *Inter-temporal Welfare Dynamics: Extents and Causes*, Conference paper given at Brookings Institution/Carnegie Endowment Workshop, Globalization: New Opportunities, New Vulnerabilities.
Available at: http://www.ceip.org/files/pdf/shahin_dynamics.pdf